



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2026 оны 03 сарын 02 өдөр

Дугаар Б/13

Баян-Овоо сум

┌ Д.Золзаяаг ажилд томилох тухай ┐

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт (сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ), Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 224 дүгээр тогтоолын 1 дэх заалт (шинжлэх ухаан, эрүүл мэнд, боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай), 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 491 дүгээр тогтоол (төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам), Боловсролын сайдын 2026 оны 01 сарын 26-ны өдрийн А/20 тушаал (Боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай)-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дондовын Золзаяаг биеийн тамирын багш дутагдалтай байгааг үндэслэн 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс багшийн үүрэгт ажилд томилсугай.

2. Биеийн тамирын багш Д.Золзаяагийн сарын үндсэн цалинг ТҮБД-3 зэрэглэлээр тогтоон 2,226,000 (хоёр сая хоёр зуун хорин зургаан мянга) төгрөгөөр, орон нутагт ажилласны нэмэгдлийг 40 хувиар тус тус тооцож олгохыг нягтлан бодогч (Г.Баасансүрэн)-д зөвшөөрсүгэй.

3. Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг багш Д.Золзаяад үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ  Ч.БОЛОРМАА



2326010037